



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/122/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот</p> <p>2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
Залруулсан алдаа .....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	16
Аудитын зөвлөмж .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал .....	16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



ЗАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ө.МАРТ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/86

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь Корона вирус ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

2021 А4 ТООТ

• 095020049

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>43,451,213.95</u></b>	<b><u>118,999,312.80</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	19,950,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	19,950,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,950,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	43,451,213.95	99,049,312.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	37,959,213.95	92,100,312.80
35110	Тусгай зориулалттай материал	37,959,213.95	92,100,312.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,492,000.00	6,949,000.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	978,000.00
35420	Аж ахуйн материал	1,453,000.00	1,932,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,039,000.00	4,039,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,053,717,148.11</u></b>	<b><u>1,117,418,620.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,053,717,148.11	1,117,418,620.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,039,245,148.11	1,102,946,620.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,024,246,647.00	1,110,464,850.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,417,531.88	-97,052,299.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,799,078.37	118,085,430.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-60,240,372.88	-74,666,529.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,292,376.00	47,892,376.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,111,486.70	-24,852,344.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	18,790,700.00
39217	Ном	1,676,438.20	4,284,438.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,472,000.00	14,472,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,472,000.00	14,472,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,097,168,362.06</u></b>	<b><u>1,236,417,933.65</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,097,168,362.06</u></b>	<b><u>1,236,417,933.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,097,168,362.06	1,236,417,933.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		147,876,387.30	147,876,387.30
51101	Өмч: - төрийн	147,876,387.30	147,876,387.30
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	302,762,041.46	442,011,613.05
51210	Өмнөх үеийн үр дүн	302,762,041.46	302,762,041.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	139,249,571.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	646,529,933.30	646,529,933.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,097,168,362.06</u></b>	<b><u>1,236,417,933.65</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>566,550,900.00</b>	<b>764,980,995.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>123,943,295.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	123,943,295.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	123,943,295.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	784,250.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	123,159,045.85
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>119,858,900.00</b>	<b>83,065,200.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	446,692,000.00	557,972,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,630,000.00</b>	<b>7,036,300.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,130,000.00	7,036,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>88,228,900.00</b>	<b>76,028,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,228,900.00	76,028,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>595,265,764.76</b>	<b>625,731,424.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>595,265,764.76</b>	<b>625,731,424.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>573,267,908.76</b>	<b>577,424,929.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>300,010,889.00</b>	<b>359,578,084.77</b>
210101	Үндсэн цалин	248,395,128.00	359,578,084.77
210102	Нэмэгдэл	16,494,684.00	00.00
210104	Урамшуулал	35,121,077.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,168,301.00</b>	<b>44,778,382.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,560,118.00	30,179,203.57
210202	Тэтгэмжийн даатгал	3,978,808.00	3,550,105.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,152,255.00	2,979,045.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,028,475.00	706,060.56
210205	Эрүүл мэндийн даатгал	12,448,645.00	7,363,967.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,778,500.00</b>	<b>72,582,077.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,215,870.00	3,318,457.00
210302	Түлш, халаалт	73,453,030.00	68,556,020.00
210303	Цэвэр, бохир ус	109,600.00	707,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,324,974.09</b>	<b>10,385,900.00</b>
210401	Бичиг хэрэг	2,410,250.00	1,465,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,680,000.00	3,880,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	652,000.00	765,000.00
210404	Ном, хэвлэл	576,100.00	471,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,293,800.00	3,693,900.00
210408	Бараа материал акталсны зардал	19,532,824.09	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,894,120.00</b>	<b>16,790,265.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	1,441,250.00

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	21,594,120.00	15,349,015.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,269,000.00</b>	<b>3,814,188.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,000.00	00.00
210602	Тавилга	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,834,000.00	3,814,188.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,575,000.00</b>	<b>1,643,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,575,000.00	1,643,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,178,184.00</b>	<b>2,053,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,974,684.00	1,603,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	203,500.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>67,068,940.67</b>	<b>65,798,832.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,928,000.00	509,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,668,900.00	3,488,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,472,040.67	61,801,782.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,997,856.00</b>	<b>48,306,495.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,941,355.00</b>	<b>25,955,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,670,320.00	8,500,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,036,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,271,035.00	10,418,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>12,000.00</b>	<b>446,823.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,000.00	446,823.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,044,501.00</b>	<b>21,903,972.23</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,044,501.00	21,903,972.23
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-28,714,864.76</b>	<b>139,249,571.59</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,963,385.08</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,963,385.08	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-9,963,385.08</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-38,678,249.84</b>	<b>139,249,571.59</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>566,550,900.00</b>	<b>641,821,950.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>784,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	784,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	784,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	784,250.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>566,550,900.00</b>	<b>641,037,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	446,692,000.00	557,972,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,630,000.00</b>	<b>7,036,300.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,130,000.00	7,036,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>88,228,900.00</b>	<b>76,028,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,228,900.00	76,028,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>566,550,900.00</b>	<b>594,089,442.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>566,550,900.00</b>	<b>594,089,442.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>546,123,544.00</b>	<b>545,782,946.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>319,810,074.00</b>	<b>359,578,084.77</b>
210101	Үндсэн цалин	254,356,650.00	261,994,376.60
210102	Нэмэгдэл	37,049,073.00	50,209,583.34
210104	Урамшуулал	28,404,351.00	47,374,124.83
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,290,300.00</b>	<b>44,778,382.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,248,531.00	29,620,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,136,501.00	3,824,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,346,900.00	2,985,643.00
210204	Ажилгүйдлийн даатгал	691,268.00	697,739.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,867,100.00	7,649,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>82,716,900.00</b>	<b>72,582,077.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,319,000.00	3,318,457.00
210302	Түлш, халаалт	78,349,900.00	68,556,020.00
210303	Цэвэр, бохир ус	48,000.00	707,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,463,850.00</b>	<b>11,666,300.00</b>
210401	Бичиг хэрэг	2,471,850.00	2,141,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,680,000.00	3,880,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	625,000.00	765,000.00
210404	Ном, хэвлэл	2,991,200.00	471,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	419,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,599,800.00	3,987,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,728,620.00</b>	<b>18,118,165.00</b>

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,000.00	1,316,350.00
210502	Хоол, хүнс	21,594,120.00	15,349,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	776,500.00	1,452,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,499,000.00</b>	<b>9,914,188.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	6,100,000.00
210602	Тавилга	16,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,499,000.00	3,814,188.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,575,000.00</b>	<b>1,643,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,575,000.00	1,643,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>32,510,000.00</b>	<b>2,053,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,183,500.00	1,603,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	326,500.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,529,800.00</b>	<b>25,448,550.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	880,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,529,800.00	24,568,550.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,427,356.00</b>	<b>48,306,495.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,370,855.00</b>	<b>25,955,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,670,320.00	8,500,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,036,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,700,535.00	10,418,900.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>12,000.00</b>	<b>446,823.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,000.00	446,823.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,044,501.00</b>	<b>21,903,972.23</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,044,501.00	21,903,972.23
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>47,732,508.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>47,732,508.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>47,732,508.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>47,732,508.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	47,732,508.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-47,732,508.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	341,440,291.30	1,135,846,611.90
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-38,678,249.84	-38,678,249.84
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	302,762,041.46	1,097,168,362.06
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	139,249,571.59	139,249,571.59
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	147,876,387.30	646,529,933.30	442,011,613.05	1,236,417,933.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	634,001,400.00	611,776,854.77	22,224,545.23	96%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,001,400.00	611,776,854.77	22,224,545.23	96%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,931,500.00	592,857,454.77	17,074,045.23	97%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,639,300.00	359,578,084.77	11,061,215.23	97%
210101	Үндсэн цалин	268,534,000.00	261,994,376.60	6,539,623.40	98%
210102	Нэмэгдэл	52,284,800.00	50,209,583.34	2,075,216.66	96%
210104	Урамшуулал	49,820,500.00	47,374,124.83	2,446,375.17	95%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,136,200.00	44,778,382.00	5,357,818.00	89%
210201	Тэтгэврийн даатгал	34,836,500.00	29,620,300.00	5,216,200.00	85%
210202	Тэтгэмжийн даатгал	3,824,900.00	3,824,900.00	0.00	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,060,000.00	2,985,643.00	74,357.00	98%
210204	Ажилгүйдлийн даатгал	765,000.00	697,739.00	67,261.00	91%
210205	Эрүүл мэндийн даатгал	7,649,800.00	7,649,800.00	0.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,028,900.00	72,582,077.00	446,823.00	99%
210301	Гэрэл, цахилгаан	3,869,000.00	3,318,457.00	550,543.00	86%
210302	Түлш, халаалт	68,649,900.00	68,556,020.00	93,880.00	100%
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	707,600.00	-197,600.00	139%
2104	Хангамж, бараа материалын зардал	13,374,800.00	13,354,300.00	20,500.00	100%
210401	Бичиг хэрэг	2,141,600.00	2,141,600.00	0.00	100%
210402	Тээвэр, шатахуун	3,880,000.00	3,880,000.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	785,400.00	765,000.00	20,400.00	97%
210404	Ном, хэвлэл	2,159,900.00	2,159,900.00	0.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	419,900.00	100.00	100%

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,987,900.00	3,987,900.00	0.00	100%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,171,900.00</b>	<b>18,118,165.00</b>	<b>53,735.00</b>	<b>100%</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,290,100.00	1,316,350.00	-26,250.00	102%
210502	Хоол, хүнс	15,429,000.00	15,349,015.00	79,985.00	99%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,452,800.00	1,452,800.00	0.00	100%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,838,700.00</b>	<b>41,838,696.00</b>	<b>4.00</b>	<b>100%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.00	7,200,000.00	0.00	100%
210604	Урсгал засвар	34,638,700.00	34,638,696.00	4.00	100%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,644,500.00</b>	<b>1,643,500.00</b>	<b>1,000.00</b>	<b>100%</b>
210702	Дотоод албан томилолт	1,644,500.00	1,643,500.00	1,000.00	100%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,395,700.00</b>	<b>1,395,700.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	945,700.00	945,700.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39701500.00</b>	<b>39568550.00</b>	<b>132,950.00</b>	<b>100%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,701,500.00	24,568,550.00	132,950.00	99%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24069900.00</b>	<b>18919400.00</b>	<b>5,150,500.00</b>	<b>79%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,069,900.00</b>	<b>18,919,400.00</b>	<b>5,150,500.00</b>	<b>79%</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,651,000.00	8,500,500.00	5,150,500.00	62%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,418,900.00	10,418,900.00	0.00	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>634,001,400.00</b>	<b>611,776,854.77</b>	<b>22,224,545.23</b>	<b>96%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>557,972,500.00</b>	<b>536,194,777.77</b>	<b>21,777,722.23</b>	<b>96%</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	557,972,500.00	536,194,777.77	21,777,722.23	96%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>76,028,900.00</b>	<b>75,582,077.00</b>	<b>446,823.00</b>	<b>99%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	76,028,900.00	75,582,077.00	446,823.00	99%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>31.00</b>	<b>4</b>	<b>89%</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	19.00	3.00	86%
620003	Үйлчлэх ажилтан	12.00	11.00	1.00	92%
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>282.00</b>	<b>282.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
630001	Төрийн өмчит ЕБС	282.00	282.00	0.00	100%
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>35.00</b>	<b>31.00</b>	<b>4.00</b>	<b>89%</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	34.00	31.00	3.00	91%

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>31,630,000.00</b>	<b>7,694,300.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>31,630,000.00</b>	<b>7,694,300.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	31,630,000.00	658,000.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,812,500.00	00.00
210101	Үндсэн цалин	4,812,500.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	687,500.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	687,500.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,130,000.00	658,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,130,000.00	658,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	7036300.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	7,036,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,036,300.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	31630000.00	7694300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,630,000.00	7,694,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,630,000.00	7,036,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	658,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Ө.Март танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 08-аас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Заг сумын Ерөнхий боловсролын нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 41 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг бага, суурь, бүрэн дунд боловсролыг хамран тойрох багийн хүүхдүүд, иргэдэд тэгш олгож, боловсрол эзэмшүүлэх, сургалт болон соёл хүмүүжлийн ажил, олон нийтийн оролцоог тулгуурлан чанар хүртээмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэн үдийн цайгаар үйлчлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 оны 4 дүгээр улирлын хамруулан шалгалт хийсэн, харин 2020 онд харьяа орон нутаг дахь Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 409903.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8198.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 625731.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12514.6 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1236417.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 139249.6 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	43,451.2	118,999.3	75,548.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	19,950.0	19,950.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,451.2	99,049.3	55,598.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,053,717.1	1,117,418.6	63,701.5
Үндсэн хөрөнгө	1,188,486.5	1,313,989.8	125,503.3
Хуримтлагдсан элэгдэл	(134,769.4)	(196,571.2)	(61,801.8)
<b>Нийт хөрөнгө</b>	1,097,168.4	1,236,417.9	139,249.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,097,168.4	1,236,417.9	139,249.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,097,168.4	1,236,417.9	139,249.6

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 19950.0 мянган төгрөг болж өссөн нь жилийн эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор 9950.0 мянган төгрөгийн өртөг бүхий ухаалаг самбарыг авахаар “Санко Маркетинг Монголиа” ХХК руу шилжүүлсэн бөгөөд хөрөнгийг тайлант онд хүлээн аваагүй учир санхүүгийн тайланд авлагаар тусгасан. Мөн урлагийн заалны тохижилт, урсгал засварт сургуулийн захирал гэрээ байгуулан “Энх Баялаг” ХХК рүү 10000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч тус ажил хийгдээгүй тул санхүүгийн тайлангийн аудитаар залруулж авлагаар бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99049.3 мянган төгрөг болж 55598.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалд ОНХС-гийн хөрөнгөөр 15000.0 мянга, аймгийн БСУГ-аас 30388,3 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэрүүн үнэ төлбөргүй авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1313989.6 мянган төгрөг болж 125503.3 мянган төгрөгөөр өссөн нь НҮБ-ийн сангийн төслөөр Дотуур байрны хүүхдийн зөөврийн халуун усыг 55393,7 мянган төгрөгөөр байгуулсан, Аймгийн БСУГ-аас 3586,3 мянган төгрөгийн зөөврийн компьютер 2 ширхэг, 18790.7 мянган төгрөгийн “Эко” нойлыг тус тус үнэ төлбөргүй орлого авсан, спорт заалны шалны засварын ажлыг 27824.5 мянга, дотуур байрны өрөөнүүдийн хаалгыг 3000.0 мянган төгрөгийн өртгөөр засварласан, төсвийн хөрөнгөөр 16908.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1236417.9 мянган төгрөг болж 139249.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 139249.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 764980.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 198430.1 мянган төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үнэ төлбөргүй авсан орлого байна. Үнэ төлбөргүй авсан орлого 123943.3 мянган, санхүүжилтийн орлого 111280,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Нийт зардал 625731.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 30465.7 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 30465,7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 578652.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 578652.4 мянган төгрөгөөр тооцон суралцагчдын тоог 355, ажиллагсдыг 35 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 55349.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж анх 657982.8 мянган төгрөгөөр баталж 2 удаагийн зохицуулалт хийж 634001.4 мянган төгрөгөөр баталсан байна. Суралцагчдын тоог 282, ажиллагсдыг 35 орон баталсан байна. Цалин, НДШ-ын зардал, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бууруулан бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 634001.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 557972.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 76028.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 536194.8 мянга, орон нутгийн төсвөөс 75582.01 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 611776.8 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 21777.7 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 446.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 611776.8 мянган төгрөг буюу 96,5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 11061.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 446.8 мянга, хангамж бараа материалын зардлыг 20.5 мянга, НДШ зардлыг 5357.8 норматив зардлыг 53,7 мянга, бараа үйлчилгээний зардлыг 132.9 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж 5150.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэх бодис, сургалтын үйл ажиллагааг зогсоосон зэргээс шалтгаалжээ.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй

/мян.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
НИЙТ	634,001.40	611,776.90	22,224.50	2,867.10	
Хөтөлбөр71802	Заг сумын ЕБС	625,151.50	602,976.30	22,175.20	2,398.38
Арга хэмжээ 80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	76,028.90	75,582.10	446.80	99.4
Арга хэмжээ 80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	10,418.90	10,418.90	0.00	100.0
Арга хэмжээ 81801	Үдийн цай хөтөлбөр	13,651.00	8,500.50	5,150.50	62.3
Арга хэмжээ 81806	Дотуур байрны хүүхдийн хоол	49,196.40	48,007.30	1,189.10	1,095.18

**Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Арга хэмжээ 81834	Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйлчилгээ	320,436.90	315,687.30	4,749.60	98.5
Арга хэмжээ 81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	155,419.40	144,780.20	10,639.20	943.00
Хөтөлбөр 71806	Насан туршийн болон албан бус боловсрол	8,849.90	8,800.60	49.30	468.72
Арга хэмжээ 80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	8849.9	8800.6	49.3	468.7158

Эх сурвалж: Төсвийн хэлбэлзлийн хөтөлбөртэй тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	9	8	1
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	4	4	4	0
4	Сар бүр	12	36	36	0
5	Тухай бүр	12	96	92	4
	Нийт		149	144	5

мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, оруулахаас төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрээс 2, бусад хяналт шалгалтын дүнгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Тайлант онд аудитаар нийт 38854.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10000.0 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага 6296.1 мянган төгрөгийн 1, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 9950.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч 12608.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулав.

#### Залруулсан алдаа

1. Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн тулган шалгахад 2608.0 мянган төгрөгийн номыг бусад хангамжийн материал дээр бүртгэснийг УСНББОУС-17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

2. Сургуулийн захирлын 2020.12.16-ны өдрийн 99 тоот тушаалаар 10000.0 мянган төгрөгийг урлагийн заалны тохижилт, урсгал зардалд зарцуулахаар “Энх Баялаг” ХХК-тай гэрээ хийж шилжүүлсэн бөгөөд засвар, тохижилтын ажил хийгдээгүй байхад барилга дансанд сайжруулалтаар орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн зарчим, 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад

бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. гэсэн заалтуудыг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

1. Тус сургуулийн нярваар ажиллаж байсан П.Жаргалсайханыг Заг сумын сургуулийн захирал Ө.Мартын 2018.09.28-ны өдрийн 42 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөнд иргэн П.Жаргалсайхан хуулийн байгууллагад хандаж, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 131/ШШ2020/00311 тоот захирамжаар 2018.09.28-2019.11.01-ний өдөр хүртэлх хугацааны цалин, НДШ 6,948,201 төгрөгийг олгохоор тогтоосныг 2020 оны 4 сард 6165191 төгрөг, 12-р сард 130947 төгрөг нийт 6296138 төгрөгийг тус байгууллагын 2020 оны цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан 6296.2 мянган төгрөгийн хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх ажиллах албан шаардлагыг Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлэх

2. Сургуулийн захирлын 2020.12.16-ны өдрийн 99 тоот тушаалаар 10000.0 мянган төгрөгийг урлагийн заалны тохижилт, урсгал зардалд зарцуулахаар Энх Баялаг ХХК-тай "Заг сумын ЕБС-ийн урлагийн зааланд засвар хийх, тохижуулах, ажлын гэрээ" гэрээ хийж шилжүүлсэн ба тус гэрээний 2.1-д "Төлбөр бүрэн орж ирснээс хойш 14 хоногоос хэтрүүлэлгүй барааг худалдан авагчид шилжүүлнэ. 2.2-д "Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлын чанарын стандартын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ." Гэсэн заалтыг зөрчин гэрээний үүргээ биелүүлэлгүй урлагийн заалны засвар, тохижилтын ажил хийгдээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэний хуулийн 351.1-д заасан үүргээ биелүүлээгүй улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх" заалтын дагуу засвар, тохижилтын 10000.0 мянган төгрөгийг Энх баялаг ХХК-аар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 9950.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Байхгүй

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Балансын данстай холбоотой асуудал**

1.1.Илрүүлэлт: Аймгийн БСУГ-ын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар ЕБС-дад "хичээл практик"-ийн зардлыг 10000.0 мянган төгрөгөөр

нэмэгдүүлсэн байна. Үүний дагуу “Санко Маркетинг Монголиа” ХХК -руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**1.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

**1.3. Өгсөн зөвлөмж:** “Санко Маркетинг Монголиа” ХХК-иас хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, “Ковид-19” цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашигтай зарцуулж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй ажиллах.

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **2. Зардлын данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, оруулахаас төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрээс 2, бусад хяналт шалгалтын дүнгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.2. Эрсдэл:** Шилэн дансны мэдээллийн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулаагүй байх

**2.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>1</sup>, 7.1.3<sup>2</sup> заалтын дагуу шилэн дансанд мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6, 6.4.8 дахь заалтын дагуу байгууллагын удирдлагын гаргасан шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөрчлийг давтан гаргахгүй аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

<sup>1</sup> Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

<sup>2</sup> тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.АЛТАНТУЯА  
ОГНОО: 2021.02.25

А.ЦЭЭНЯМ  
ОГНОО: 2021.02.25

Б.МӨНХБАТ  
ОГНОО: 2021.02.25

**5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/22/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Заг сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Тус сургуулийн нярваар ажиллаж байсан П.Жаргалсайханыг Заг сумын сургуулийн захирал Ө.Мартын 2018.09.28-ны өдрийн 42 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөнд иргэн П.Жаргалсайхан хуулийн байгууллагад хандаж, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 131/ШШ2020/00311 тоот захирамжаар 2018.09.28-2019.11.01-ний өдөр хүртэлх хугацааны цалин, НДШ 6,948,201 төгрөгийг олгохоор тогтоосныг 2020 оны 4 сард 6165191 төгрөг, 12-р сард 130947 төгрөг нийт 6296138 төгрөгийг тус байгууллагын 2020 оны цалингийн зардлаас олгосон байна.	6296.1	Албан шаардлага өгөх	Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга	Д.Даваажаргал
2	Сургуулийн захирлын 2020.12.16-ны өдрийн 99 тоот тушаалаар 10000.0 мянган төгрөгийг урлагийн заалны тохижилт, урсгал зардалд зарцуулахаар Энх Баялаг ХХК-тай гэрээ хийж шилжүүлсэн байхад засвар, тохижилтын ажил хийгдээгүй байхад барилга дансанд орлого авсан байна.	10000.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Март, У.Сүхбаатар
3	"Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгасан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000,0	9950.0	Зөвлөмж хүргүүлэх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Март, У.Сүхбаатар

Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байна.				
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, оруулахаас төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрээс 2, бусад хяналт шалгалтын дүнгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Март, У.Сүхбаатар
5	Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн тулган шалгахад 2608.0 мянган төгрөгийн номыг бусад хангамжийн материал дээр бүртгэсэн.	2608.0	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Март, У.Сүхбаатар
6	Сургуулийн захирлын 2020.12.16-ны өдрийн 99 тоот тушаалаар 10000.0 мянган төгрөгийг урлагийн заалны тохижилт, урсгал зардалд зарцуулахаар "Энх Баялаг" ХХК-тай гэрээ хийж шилжүүлсэн бөгөөд засвар, тохижилтын ажил хийгдээгүй байхад барилга дансанд сайжруулалтаар орлого авсан.	10000.0	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ө.Март, У.Сүхбаатар
<b>ДҮН</b>		<b>38854.1</b>			

оОо